

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН 56 ДУГААР ЗҮЙЛД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ
САНАЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зөвшилцөхөөр Улсын Их Хуралд ирүүлсэн Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг дэмжив.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БАТТӨМӨР